

НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

Д/д	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	Нэр Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Өөлд овогт Пүрэвийн Оюунчимэг
2	Хүсэлт гаргагчийн хаяг Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	
3	Төрсөн огноо Төрсөн газар	
4	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их сургуульд 2008-2009 онд суралцаж төгссөн. Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан. №F20092995 - Монгол Улсын Их сургуульд 1994-1996 онд суралцаж төгссөн. Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. №96/883 - ОХУ-ын Иркутскийн их сургуульд 1987 онд элсэж, 1993 онд МУИС-ыг төгссөн. №23798 - Шүүх яамны харьяа Улаанбаатар дахь Хууль цаазын дунд сургуульд 1982-1984 онд суралцаж, Хуульч мэргэжлээр төгссөн. Дипломын дугаар №2073
5	Ажил эрхлэлт Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын нэр: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Байгууллагын хаяг: Чингэлтэй дүүрэг, Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын 11 дүгээр байр, 5 давхар Утас: 51-260987 Вэб сайт: https://www.nhrcm.gov.mn/ Ажлын байрны нэр: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Гишүүн - Байгууллагын нэр: Нийслэлийн Прокурорын газар Ажлын байрны нэр: Хяналтын прокурор - Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Прокурорын газар Ажлын байрны нэр: Хяналтын прокурор
6	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнд нэр дэвшиж байгаа.

7	<p>Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил Хүсэлт гарагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. 	<p>1. Албан тушаалын нэр: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Гишүүнээр 2007.02.06-наас одоог хүртэл, Ажлын албаны даргаар 2005.09.29-нөөс 2005.09.29 хүртэл, Референтээр 2001.12.20-ноос 2005.09.29 хүртэл тус тус ажилласан. Улсад нийт 26 жил 8 сар ажилласнаас Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комисст 18 жил 5 сар ажилласан байна.</p> <p>байгууллагын хаяг: Чингэлтэй дүүрэг, Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын 11 дүгээр байр, 5 давхар, утас: 51-260987 вэб сайт: https://www.nhrcm.gov.mn/</p> <p>албан тушаалын тодорхойлолт: Комиссын гишүүний хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, арилгуулах талаар шаардлага гаргаж эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах, шийдвэрлэх, эрх нь зөрчигдсөн иргэнийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах болон хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх</p> <p>2. албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; Баянгол дүүргийн Прокурорын газрын хяналтын Прокурор, Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор, Баянзүрх дүүргийн Прокурорын газрын хяналтын прокуророор нийт Прокурорын байгууллагад тус тус нийт 8 жил 3 сар ажилласан байна ажлын байрны тодорхойлолт; Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцох эрхийг хэрэгжүүлнэ.</p>
8	<p>Ёс зүй Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> -сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх; -сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх. 	<p>үгүй</p>
9	<p>Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний 	<p>1. үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; Улаанбаатар хотод 2019.06.27-2019.06.28-нд зохион байгуулагдсан Олон Улсын Нотариатын Холбооны Азийн хэрэг эрхлэх Комиссын 9 дүгээр хуралд илтгэгчээр оролцож, “Өмчлөх эрхийн олон улсын болон дотоодын эрх зүйн зохицуулалт” сэдвээр илтгэл тавьсан.</p> <p>үйл ажиллагааны гол агуулга; Нотариатын нийгэмд гүйцэтгэх үүргийг зөвхөн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, өмчлөх эрх шилжүүлэх, өвлөх харилцааг зохицуулах зэргээр хязгаарлахгүйгээр олон улсын хэмжээнд тулгамдаж буй мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд тэмцэхэд нотариатын гүйцэтгэх үүрэг, нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, насанд хүрээгүй, өндөр настай иргэдийн хөрөнгийн эрхийн хамгаалалт, түүнд нотариатын байгууллагын гүйцэтгэх үүрэг, оролцоо чухал болохыг хөндсөн.</p> <p>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн</p>

<p>жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.</p>	<p>хамгаалалтыг сайжруулахад нотариатч чухал үүрэг гүйцэтгэж болох, эн үүрэг ямар хэлбэрүүдээр хэрэгжиж болохыг орчин үеийн тулгамдсан асуудал болоод байгаа мөнгө угаах, терроризмтэй тэмцэхэд нотариатчийн үүргийн талаар улс орнууд туршлага хуваалцсан. хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар: Монголын Нотариатчдын Танхим, Олон Улсын Нотариатын Холбооны Азийн хэрэг эрхлэх Комиссын 9 дүгээр хурлын илтгэл, хэлэлцүүлгийн эмхэтгэл, 76-85 тал, 2019 он.</p> <p>2. үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос 2018.03.03-04-ний өдрүүдэд Хууль сахиулахын их сургууль дээр зохион байгуулсан хуралд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүний эрхийн талаарх зохицуулалт: олон улсын гэрээ, хууль, практик” сэдвээр илтгэл тавьсан.</p> <p>үйл ажиллагааны гол агуулга; 2017.07.01-ний өдрөөс хэрэгжижи эхэлсэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцсэн.</p> <p>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, хүний эрхийг хангах, хамгаалахад ахиц гаргах, празтикт хуулиас давсан журам гарч байгааг цэгцлэх, шинээр зарим, зүйл заалт нэмэх гэх зэрэг саналыг хууль зүйн үндэслэлтэй гаргаж тавьсан.</p> <p>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар: Илтгэлийн хуулбарыг хавсаргав.</p> <p>3. Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Тагнуулын дээд сургууль хамтран Хууль зүйн хүрээлэнд зохион байгуулсан хуралд “Дэлхийн улс орнуудын эрүүгийн процессын хуулиуд дахь хүний эрхийн хамгаалалт” сэдвээр илтгэл тавьсан. 2017 он.</p> <p>үйл ажиллагааны гол агуулга; Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг сайжруулах талаар санал, дүгнэлт гаргах зорилготой.</p> <p>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Эрүүгийн процессын хуулиуд дахь хүний эрхийн хамгаалалтын асуудлыг олон улс орны жишээн дээр, тухайн улсуудын хуулийн зохицуулалтыг харьцуулж дүн шинжилгээ хийж гаргаж тавьсан.</p> <p>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар: Илтгэлийн хуулбарыг хавсаргав</p> <p>4. үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; Ази Номхон Далайн Хүний эрхийн Форум" болон Австралид төвтэй "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ассоциаци" олон улсын байгууллагаас 2014-2016 онд Ази Номхон далайн бүсийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын дунд "Эрүү шүүлтийн эсрэг Элчин сайд" сонгон ажиллуулах хөтөлбөрт бүсийн 21 хүний эрхийн үндэсний байгууллагаас шалгаруулалт хийж, хүний эрхийн 7 байгууллагын 11 төлөөлөгчийг сонгон шалгаруулахад сонгогдон ажилласан.</p> <p>үйл ажиллагааны гол агуулга; Хүний эрхийн үндэсний байгууллагуудыг эгнээндээ нэгтгэдэг</p>
--	--

		<p>Австралийн Сидней хотноо төвтэй Ази, Номхон Далайн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулган болон Швейцарийн Женевт төвтэй Эрүү Шүүлтээс Урьдчилан Сэргийлэх Хороо хамтран Ази Номхон далайн бүсийн хэмжээнд ажилладаг хүний эрхийн үндэсний байгууллагуудаас "Эрүү шүүлтийн эсрэг Элчин сайд" нарыг 2014-2016 онд томилон ажиллуулсан юм.</p> <p>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. http://www.mnb.mn/i/37861</p> <p>5. үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Нээлттэй нийгэм форумаас Их тэнгэр цогцолборт 2012.04.27-ны өдөр зохион байгуулсан “Нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах нь” Олон улсын бага хуралд “Хүний эрхийн үндэсний байгууллагаас шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа өнөөгийн нөхцөл байдал болон гарч буй хүндрэлүүд” сэдвээр илтгэл тавьсан.</p> <p>үйл ажиллагааны гол агуулга; Нийтийн эрх ашгийг сэргээх ийм алхам нь нийгэмд шударга ёсыг тогтоох, түүний ач холбогдол, хууль хяналтын байгууллага, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын үйл ажиллагаатай хүний эрхийг хангах, хамгаалахад шууд холбоотой талаар хэлэлцүүлэг өрнүүлж, олон улс орны төлөөлөл өөрсдийн орны туршлагаас хуваалцсан.</p> <p>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. https://zindaa.mn/l4u , Илтгэлийн хуулбарыг хавсаргав.</p> <p>6. үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; Монголын Хуульчдын Холбооноос 2015 онд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгосон. Гэрчилгээний дугаар №4697</p> <p>үйл ажиллагааны агуулга: Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагаанд оролцох, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлнэ.</p> <p>үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн туслалцаа үзүүлэх, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зохих байгууллагад төлөөлөх, нэхэмжлэл, хүсэлтийг шийдвэрлэх, хохирол барагдуулахад чиглэсэн аливаа зөвшилцөх, эвлэрүүлэх үйл ажиллагаа явуулах, шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох зэргээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулна.</p> <p>хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. Гэрчилгээний хуулбарыг хавсаргав.</p> <p>7. үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; МУИС-д 2010 онд Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудлууд: Онол, практик сэдвээр Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан. Докторын дипломын дугаар № F20092995.</p> <p>үйл ажиллагааны агуулга: Эрүүдэн шүүхээс урьдчилсан сэргийлэх, таслан зогсоох, түүнтэй тэмцэх асуудлыг олон улсын эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа, тэдгээрийн сайн</p>
--	--	---

		<p>туршлагад үндэслэн гаргаж тавьсан. Дипломын удирдагч багш: Хууль Зүйн ухааны Докторын зэрэг хамгаалсан. хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. Дипломын хуулбарыг хавсаргав.</p> <p>8. үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; МУИС-д 1996 онд Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. Дипломын дугаар №96/883 үйл ажиллагааны агуулга: МУИС-ын магистрын сургалтын хөтөлбөрийг бүрэн биелүүлсэн тул Хууль зүйн ухааны магистрын зэрэг олгосон. хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. Дипломын хуулбарыг хавсаргав.</p> <p>9. үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын Газар Хүний эрх ба Ардчиллын институтээс хамтран 2011 оны 10 дугаар сарын 12,13-ны өдрүүдэд “Төв Ази дахь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд Парисын зарчмын дагуу байгуулагдсан Хүний Эрхийг Хамгаалах Үндэсний Байгууллагуудын үүрэг, роль” сэдэвт бүсийн семинарийг Тажикстаны Душанбе хотноо зохион байгуулсан юм. НҮБ-ын ХЭДГ-аас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссыг төлөөлөн тус арга хэмжээний эксперт зөвлөхөөр ажиллах санал тавьсны дагуу оролцсон. Энэ нь манай улсын Хүний эрхийн Үндэсний байгууллагаас олон улсын хэмжээнд НҮБ-ын эксперт зөвлөхөөр ажилласан анхны тохиолдол юм. үйл ажиллагааны агуулга: Узбекистан, Тажикистан, Казакстан, Кыргызстан, Армян, Гүрж зэрэг улсын хүний эрхийн ажилтнууд, хуулийн байгууллагынхныг оролцуулсан тус семинарт Монгол Улсын ХЭҮК-ын гишүүн манай улсын хүний эрхийг хамгаалах тогтолцоо, хүний эрхийг хамгаалах, хангах, хүний эрхийн сургалт, өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагааны талаар болон Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсанаас хойш хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үр дүн, улс орны хэмжээнд зохион байгуулсан эрүү шүүлтийн эсрэг нээлттэй хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах аргачлал, туршлага зэрэг сэдвийг хөндсөн илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна. үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; Англи, орос хэл дээр зохиогдсон энэхүү арга хэмжээний үр дүнд Дундад Азийн орнуудын Хүний эрхийн омбудсман, Хүний эрхийг Хамгаалагч нарт цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд зориулсан “Душанбегийн Тунхаглал” хэмээх баримт бичгийг батлан гаргасан байна. хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. http://nhrcm.gov.mn/</p> <p>10. үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Хүний эрх-хүнд сурталгүй нийгэм” сэдэвт чуулганыг 2008.11.16-ны өдөр зохион байгуулав. хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. http://gogo.mn/r/36ggZ, http://legaldata.mn/b/532, Ажлын хэсэг байгуулсан тушаалыг хавсаргав.</p>
10	Хүний эрхийг хөхиүлэн дэмжих,	

<p>хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил Хүсэлт гарагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. 	<p>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих чиглэлээр</p> <p>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст нийт 18 жил ажиллаж байна.</p> <p>Энэхүү ажиллах хугацаандаа хүний эрхийг хөхиүлэн дэмжих чиглэлээр хууль хяналтын байгууллага, иргэдэд зориулсан нийт 300 гаруй сургалтыг амжилттай зохион байгуулж, хүний эрхийн тодорхой асуудлаар гадаад, дотоодын 60 гаруй онол, практикийн болон эрдэм шинжилгээний хурал, олон улсын хурлуудад илтгэл тавьж 30 гаруй эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл, орчуулгын ном, товхимолыг бие даан боловсруулж, хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгожээ. Хууль зүйн Үндэсний төвд явагддаг хуульчдын давтан сургалт, Хууль сахиулахын Их сургуулийн Цагдаагийн сургуулийн эчнээ, эрх зүйн салбарын оюутнууд, цагдаагийн албан хаагчдын давтан сургалтанд хамрагдагсад, төгсөх курсын сонсогч, магистрантурын ангийн оюутнуудад “Эрүүдэн шүүхийн эсрэг олон улсын механизм”, “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрх”, “Хүний эрхийн олон улсын ойлголт стандарт” зэрэг олон төрлийн сэдвүүдээр тогтмол сургалт явуулж байна.</p> <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудын албан хаагчдыг “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургагч багш”-аар, 2017-2018 онуудад Цагдаагийн байгууллагын 45, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 38, Зэвсэгт хүчний 40 алба хаагчийг тус тус “Хүний эрхийн сургагч багш”-аар бэлтгэсэн.</p> <p>ХСИС, Отгонтэнгэр хууль зүйн сургууль болон Тагнуулын академийн магистрын ангийн оюутнуудад хүний эрхийн хичээл зааж, доктор болон магистрын ажлын удирдагч багшаар ажилладаг ба Хууль Сахиулах Их сургуулийн дэд профессор, профессорын судалгааны багийн зөвлөх профессороор ажиллаж байна. Мөн хуульчдын кредит цаг олгох сургалтын 8 гарын авлагыг боловсруулан батлуулж хуульчдад кредит олгох сургалтанд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрх.олон улсын гэрээг хууль шүүхийн практикт хэрэглэх сэдвүүдээр хичээл зааж байна.</p> <p>Цагдаагийн Ерөнхий газар, Цагдаагийн академитай хамтран хуулийн сургуулиудын оюутнуудын хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэх, хүний эрхийн асуудлаар мэдрэмжтэй чадварлаг боловсон хүчин бэлтгэхэд нөлөө үзүүлэх зорилгоор тус сургууль дээр “Хүний эрхийн сургалтын төв”ийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран байгуулж, тус академийн сонсогч, давтан сургалтын цагдаагийн албан хаагч нарт эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлттэй тэмцэх талаарх сургалт, оюутны мэтгэлцээн, семинарийн хичээлийг тогтмол явуулж байна.</p> <p>Мөн Монголын хуульчдын холбоогоор магадлан итгэмжлүүлсэн сургалтын хөтөлбөрүүдэд ХЭҮК-оос хуульчдын багц цаг хангах үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт магадлан итгэмжлүүлэхээр 17 сэдвийг хүргүүлснээс дараах хөтөлбөрүүдийг магадлан итгэмжилсэн байна. Үүнд:</p>
--	---

		<ol style="list-style-type: none"> 1. Нийтийн хэв журам ба хүний эрх 2. Хүүхдийн эрх ба хамгаалал 3. Эрүү шүүлтээс ангид байх эрх 4. Хүний эрхийн олон улсын гэрээ 5. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа ба хүний эрх 6. Үндсэн хууль ба хүний эрх <p>Жич: Монголын Хуульчдын Холбооны Ерөнхийлөгчид 2020.01.16-ны өдөр хүргүүлсэн албан бичгийн хуулбарыг болон хавсаргав.</p> <p>Хүний эрхийг хамгаалах чиглэлээр</p> <ol style="list-style-type: none"> 1. Комиссын гишүүнээр ажиллах хугацаандаа хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд гомдол шалгаж шийдвэрлэж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж, хүний эрхийн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох чиглэлээр шаардлагыг эрх бүхий байгууллага албан тушаалтанд хүргүүлж, хүний эрхийн аливаа асуудлаар хяналт шалгалт хийж, иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах зэргээр ажиллаж байна. <p>Жич: Төлөөлөн гаргасан нэхэмжлэлтэй холбоотой шүүхийн шийдвэрийн хуулбарыг болон Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хуулбарыг хавсаргасан болно.</p> <ol style="list-style-type: none"> 2. Үндэстний цөөнхийн нэг болсон цаатан иргэдийн эрхийн төлөв байдлыг дагнан судлах, үндэстний цөөнхийн талаарх төрөөс баримталбал зохих үйл ажиллагааг чиглүүлэх зөвлөмж боловсруулах, Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын дунд сургуулийн духа хүүхдүүдэд зориулсан “Тува хэлний хөтөлбөр” боловсруулахад идэвхтэй ажилласан ба энэ чиглэлээр тасралтгүй 10 жил ажилласан. 3. Комиссын тухай хуулийн 13.1.1, 13.1.2, 13.1.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлаар хэлэлцэх хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөлд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийж, 2013 онд 20, 2014 онд 25, 2015 онд 30, 2016 онд 40, 2017-2020 он хүртэлх хугацаанд хуулийн төсөл, бодлогын баримт бичигт санал боловсруулан хууль санаачлагчдад хүргүүлсэн байна. 4. 2005 онд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг Тусгай илтгэгч ноён Манфред Новакийн Монгол улсад хийсэн айлчлалыг амжилттай зохион байгуулж ажлын хэсгийг ахалж ажилласан. 5. 2011 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Дундад Азийн улсуудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, тэмцэх асуудлаарх хуралд олон улсын зөвлөхийн статустайгаар анх ажиллуулсан бөгөөд энэ нь Монгол Улсын Хүний эрхийн үндэсний байгууллагын хийж гүйцэтгэж байгаа ажлыг олон улсын түвшинд үнэлж байгаагийн нэг илрэл болсон гэж үздэг. 6. Ази тивийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудыг эгнээндээ нэгтгэдэг "Ази Номхон
--	--	--

		<p>Далайн Хүний эрхийн Форум" болон Англид төвтэй "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ассоциаци" олон улсын байгууллагаас 2014-2016 онд Ази Номхон далайн бүсийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын дунд "Эрүү шүүлтийн эсрэг Элчин сайд" сонгон ажиллуулах хөтөлбөрт бүсийн 21 хүний эрхийн үндэсний байгууллагаас шалгаруулалт хийж, хүний эрхийн 7 байгууллагын 11 төлөөлөгчийг сонгон шалгаруулахад сонгогдон ажилласан.</p> <p>7. 2014 онд Америкийн Нэгдсэн улсын Департаментаас гаргасан дэлхийн улс орнуудын олон улсын манлайлагчдын хөтөлбөрт бүсээсээ шалгаран оролцож Америкийн хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах харилцан туршлага солилцох ажлыг амжилттай зохион байгуулсан.</p>
11	<p>Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал</p> <p>Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. 	<p>МУХЭҮК-оос Улсын Их Хуралд жил бүр өргөн барьсан Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх нийт 19 илтгэлийг боловсруулахад оролцсон байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 2001 оны байдлын тухай илтгэлийн Хүний хувийн эрх, эрх чөлөөний төлөв байдал, Хүний улс төрийн эрх, эрх чөлөөний төлөв байдал, Хүний эдийн засгийн эрхийн төлөв байдал, Хүний нийгэм, соёлын эрхийн төлөв байдал сэдвүүд 2. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 2002 оны байдлын тухай илтгэл-Нийгмийн эмзэг бүлгийн эрхийн төлөв байдал, Зарим эрхийн хэрэгжилтийн байдал, Хүний эрхийн өнөөгийн анхаарал татаж буй зарим асуудал сэдвүүд 3. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 2003 оны байдлын тухай илтгэлийн Тодорхой эрхүүдийн хэрэгжилтийн төлөв байдал, Эмзэг бүлгийн эрхийн асуудал, Хүний эрхийн анхаарал татаж буй зарим асуудал сэдвүүд 4. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 2004 оны байдлын тухай илтгэл-Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт, Зохистой хоол хүнсээр хангагдах эрхийн хэрэгжилт, Аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт сэдвүүд 5. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 2005 оны байдлын тухай илтгэл Эрүү шүүлт ба хүний эрх, Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах, хамтын гэрээ, хэлэлцээр хийх эрхийн төлөв байдал сэдвүүд 6. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 2006 оны байдлын тухай илтгэл-Цэргийн албан хаагчдын эрхийн хэрэгжилтийн төлөв байдал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, Монгол улс дахь хүний эрхийн боловсролын өнөөгийн байдал сэдвүүд 7. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 2007 оны байдлын тухай илтгэлийн Хүний эрх, эрх чөлөө, Тодорхой эрхийн талаарх судалгааны үр дүн, Хүрээлэн буй орчин ба нийтийн эрх сэдвүүд 8. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 2008 оны байдлын тухай илтгэлийн Нийслэл улаанбаатар хотод үүссэн нийтийн эмх замбараагүй байдал ба хүний эрх, Хүн худалдаалах гэмт хэрэг ба хүний эрх, Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд

		<p>худалдаалахаас урьдчилан сэргийлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсүүд сэдвүүд</p> <ol style="list-style-type: none"> 9. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний 2009 оны байдлын тухай илтгэлийн Үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт /Казах, Цаатан, Тыва/, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрхийн зарим асуудлууд сэдвүүд 10. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 10 дахь илтгэлийн Өмнөх 9 удаагийн илтгэлүүдэд холбогдон гаргасан зөвлөмжүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн талаар 11. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх илтгэлийн Хорих байгууллага ба хүний эрх, Хөдөлмөрлөх эрхтэй холбоотой зарим асуудал, Уул уурхай ба хүний эрх, Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн зарим асуудал сэдвүүд 12. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэлийн Монгол улс дахь ЛГБТ 13. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэлийн Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилт, Хөдөлмөрийн харилцаан дахь жөндөрийн тэгш байдлын зарим асуудал сэдвүүд 14. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлийн Эрүү шүүлтээс ангид байх эрх, Төрөлжсөн асрамжийн газар дахь хүний эрхийн зарим асуудал, Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа ба хүний өмчлөх эрхийн асуудал, Цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн асуудал сэдвүүд 15. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлийн Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилт, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Байгууллагын албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт сэдвүүд 16. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийн Цэргийн алба хаагч, ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал, Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилт, Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдал сэдвүүд 17. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэлийн Хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилтийн зарим асуудал, Хилийн боомтод ажиллаж буй мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал сэдвүүд 18. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийн Ажлын байран дахь бэлгийн дарамтын нөхцөл байдал, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт, Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны төлөв байдал сэдвүүд 19. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэлийн Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт сэдвийг тус тус хариуцан боловсруулж, илтгэлийн Ажлын хэсгийг ахалж ажиллав.
--	--	--

<p>12</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.</p>	<ol style="list-style-type: none"> 1. албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа: Баянгол дүүргийн Прокурорын газарт хяналтын прокурор, 2001.04.17-ноос 2001.12.19 хүртэл 2. албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа: Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокурор, 1998.09.14-нөөс 2001.03.29 хүртэл 3. албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа: Баянзүрх дүүргийн прокурорын газарт хяналтын прокурор, 2001.03.29-нөөс 2001.04.17, 1993.08.02-ноос 1998.09.14 хүртэл <p>ажлын байрны тодорхойлолт; Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцох эрхийг хэрэгжүүлнэ.</p>
<p>13</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ. -Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана. -Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Монголын Хуульчдын Холбооны гишүүн. Монголын Хуульчдын Холбооны Ерөнхийлөгчийн 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн шийдвэрээр Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгосон. Гэрчилгээний дугаар №4676 Төрийн албанд ажиллаж байгаа гэх үндэслэлээр 2015 онд шүүхэд төлөөлөх эрхээ түдгэлзүүлсэн. 2. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолын дагуу Жөндөрийн үндэсний хорооны орон тооны Гишүүнээр ажиллаж байна.
<p>14</p>	<p>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл -Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж</p>	<p>Өөрийн боловсруулсан Эрдэм шинжилгээний бүтээл, эрдэм шинжилгээний дагнасан судалгааны бүтээл, гарын авлага, сурах бичиг, тавьсан илтгэл, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд өгсөн ярилцлага, нэвтрүүлгүүд:</p>

<p>зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.</p> <p>-хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.</p> <p>Жич: Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана.</p>	<p>Нэг. Эрдэм шинжилгээний бүтээл</p> <p>1 “Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудлууд:Онол,практик МУИС-ийн Хууль зүйн Сургууль, 2009-12-21-нд Хууль Зүйн ухааны Докторын зэрэг хамгаалсан. Удирдагч-Хууль зүйн шинжлэх ухааны доктор, Академич С.Нарангэрэл</p> <p>Хоёр. Эрдэм шинжилгээний судалгааны бүтээл</p> <ol style="list-style-type: none"> 1. Хэрэгсэхгүй болгосон хэрэгт хийсэн судалгаа-2001 он 2. Хүний итгэл үнэмшилтэй байх эрхийн төлөв байдлын судалгаа-2001 он 3. Хөдөлмөрлөх эрхийн төлөв байдлын судалгаа-2001 он 4. Нийслэлд хөдөө орон нутгаас шилжин суурьшсан иргэдийн талаарх судалгаа-2002 он 5. Өмгөөлүүлэх эрх зүйн туслалцаа авах эрхийн судалгаа-2002 он 6. Иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийн талаар хийсэн судалгаа-2002 он 7. Хөдөлмөрлөх эрхийн судалгаа-2002 он 8. Хорооны хэсгийн байцаагч, цагдаа нарын үйл ажиллагаанд хийсэн судалгаа-2002 он 9. Эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалах гэмт хэргийн талаар хийсэн судалгаа-2002 он 10. Хүний эрхийг хамгаалах тогтолцоо-2002 он 11. Олон улсын эрүүгийн шүүхийн ромын дүрэм-2002 он 12. Тахир дутуу иргэдийн төлөв байдлын судалгаа-2003 он 13. Хүүхдийн эрхийн төлөв байдлын судалгаа-2003 он 14. Монгол улсын зарим хууль тогтоомж Монгол Улс нэгдэн орсон Олон улсын гэрээ хэлэлцээр болон Үндсэн хуульд заасан хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэх асуудлаарх судалгаа-2003 он 15. 1992-2003 онд батлагдсан Засгийн газрын тогтоолд хийсэн дүн шинжилгээ-2004 он 16. Тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөний төлөв байдлын судалгаа-2004 он 17. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн төлөв байдлын судалгаа-2004 он 18. Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хэрэгжилтийн судалгаа-2004 он 19. Цаатан төслийн эцсийн тайлан-2004 он 20. Үндэсний цөөнхийн эрхийн судалгаа-2005 он 21. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн байдал-2005 он 22. Ажлын байран дахь бэлгийн дарамт сэдэвт судалгаа-2005 он 23. “Мэдээлэл хайх, олж авах эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” сэдэвт судалгааны тайлан-2005 он 24. Хүний эрх-Хэрэг бүртгэх ажиллагаа-2005 он 25. Цэргийн алба хаагчдын эрхийн хэрэгжилтийн судалгаа-2006 он
---	--

		<p>26. Тува хэлний сургалтын хөтөлбөр-2006 он</p> <p>27. Замын цагдаагийн албан хаагч нарт зориулсан сургалтыг гарын авлага-2006 он</p> <p>28. “Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа-2007 он</p> <p>29. “Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн эрх” Үндэсний чуулганы эмхэтгэл, 2007 он</p> <p>30. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа-2007 он</p> <p>31. “Захиргааны шийдвэрийн улмаас хохирсон хохирогчдын эрх” судалгаа-2007 он</p> <p>32. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа-2007 он</p> <p>33. Цэргийн албан хаагчдын хүний эрхийн боловсролд-2007 он</p> <p>34. Монгол Улс дахь хүүхдийн эрхийн тэвчишгүй хэлбэрүүд судалгаа-2008 он</p> <p>35. Төрийн захиргааны байгууллага дахь хүнд суртал сэдэвт судалгааны ажлын тайлан-2008 он</p> <p>36. Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид үндэсний хууль тогтоомж хэрхэн нийцэж буй талаарх шинжээчийн үнэлгээ гаргах судалгаа-2008 он</p> <p>37. Хүүхдийн асрамж, халамжийн төвүүдийн үйл ажиллагаа болон хүүхдүүдэд үзүүлж байгаа үйлчилгээ-2009 он</p> <p>38. Хорих анги дахь хүний эрхийн нөхцөл байдал тодорхойлох судалгаа-2009 он</p> <p>39. Сэжигтэн яллагдагчийн цагдан хорих ажиллагаанд анхаарах зарим асуудлууд-2009 он</p> <p>40. Бэлгийн ижил чиг баримжаатай хүмүүсийн эрхийн хэрэгжилтийн судалгаа-2010 он</p> <p>41. Казах, Тува хүүхдүүдийн сурч боловсрох эрх, хөдөлмөр эрхлэлтийн байдал судалгааны тайлан-2010 он</p> <p>42. Алслагдсан орон нутгийн ангиудын цэргийн албан хаагчдын хүүхдийн эрхийн асуудлаарх судалгаа-2011 он</p> <p>43. Сэтгэцийн Эрүүл мэндийн Үндэсний Төвд хэвтэн эмчлүүлж буй өвчтнүүдийн эрхийн байдалд хийх дүн шинжилгээ-2011 он</p> <p>44. Цаазаар авах ялаар шийтгүүлж, Ерөнхийлөгчийн уучлалд хамрагдсан ялтнуудын асуудлын судалгаа-2011 он</p> <p>45. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч байгууллагуудын эмэгтэй албан хаагчдаас авсан судалгаа-2011 он</p> <p>46. УИХ-ын 2012 оны сонгуульд хийсэн ажиглалт, судалгаа-2012 он</p> <p>47. ШШГЕГ-ын харьяа эмэгтэйчүүдийн хорих ангид хийсэн судалгаа-2012 он</p> <p>48. Хүн амины гэмт хэрэгт ял шийтгүүлж хорих 407 дугаар ангид ял эдэлж буй эмэгтэйчүүдийн үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийн судалгаа-2012 он</p> <p>49. ХЭҮК-т гаргасан гомдлыг шалгаж шийдвэрлэх гарын авлага-2012 он</p> <p>50. Монгол Улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал судалгааны тайлан-2013 он</p>
--	--	--

		<p>51. Хууль зүйн боловсрол олгож буй их дээд сургуулиуд дахь хүний эрхийн боловсрол-2014 он</p> <p>52. Цагдаагийн байгууллагад зориулсан хүний эрхийн стандарт, туршлага-2014 он</p> <p>53. Монгол Улс дахь заавал хаах цэргийн алба ба хугацаат цэргийн хөдөлмөр: Бодлого, практикийн дүн шинжилгээ-2016 он</p> <p>54. Гомдол хянан шалгах процесс-2017 он</p> <p>Гурав. Ном, гарын авлага</p> <ol style="list-style-type: none"> 1. ХЭҮК-т гомдол хүлээн авах, шийдвэрлэхэд зориулсан гарын авлага-2002 он 2. “Эрүү шүүлтийн тухай ойлголт” 2005 он, 5 хх. Доктор С.Жанцан хянан тохиолдуулсан. 3. Цагдаагийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтын гарын авлага, 2005 он, 200 хувь, Доктор С.Цэрэндорж хянан тохиолдуулсан. 4. “Иргэн таны эрх зүйн мэдлэгт”, ном , 2006 он 5. “Эрүү шүүлттэй тэмцэх нь” зөвлөлдөх уулзалтын эмхэтгэл, 2008 он 6. “Хүний наймаатай тэмцэх нь” үндэсний зөвлөлдөх уулзалтын эмхэтгэл, 2008 он 7. “Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх нь” илтгэлүүдийн эмхэтгэл, 2008, 2009 он /Төв, Хангай, Говь, Зүүн, Баруун бүс тус бүрээр/ 8. “Хүний эрх ба эрүү шүүлт” 2009 он 24 хх, Академич С.Нарангэрэл хянан тохиолдуулсан. 9. Эрүү шүүлтийн асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч Манфред Новакийн дэлхийн улс орнуудад эрүү шүүлтийн талаар өгсөн зөвлөмж, хэрэгжилт, орчуулгын бүтээл, 2009 он, зөвлөх Академич С.Нарангэрэл, доктор С.Цэрэндорж 10. Үндэсний цөөнх (цаатан) хүүхдийн сурч боловсрохэрх, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан-2010 он 11. Хараагүй хүмүүсийн брайль гарын авлага/Үндсэн хууль, Эрүүгийн хууль, ЭБШХ/-2010 он 12. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс арван жилд I, II боть-2011 он 13. “Нийгмийн хэв журам ба хүний эрх” Цагдаагийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтын илтгэлийн эмхэтгэл (<i>Хүний эрхийн тухай ойлголт, зарчим,түүний хязгаарлалт</i>)-2012 он 14. Цагдаагийн байгууллага ба хүний эрхийн стандарт (Хүний эрхийн тухай цагдаагийн өврийн ном) орчуулгын бүтээл-2012 он 15. Хүний эрхийн нийтлэлүүдийн эмхэтгэл 2012,2013,2015 он 16. Жогжакартын зарчмууд-2013 он 17. Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд НҮБ-ын холбогдох хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн эмхэтгэл (1977-2014)-2014 он 18. Хорих байгууллагын ажилтнуудад зориулсан Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж тогтоол, шийдвэрийн эмхэтгэл-2014 он
--	--	---

		<p>19. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Тусгай Илтгэгч Манфред Новакийн зөвлөмж, улс орнуудын илтгэлүүдийн эмхэтгэл-2014 он</p> <p>20. Эрүү шүүлтийн эсрэг олон улсын эрх зүйн эрх сурвалж ба Үндэсний илтгэлүүд, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас өгсөн зөвлөмжүүд -2015 он</p> <p>21. Монгол улс дахь хүний эрх эрх чөлөөний тухай илтгэл/2Ш6-2016 оны УИХ-д өргөн барьдаг ХЭҮК-ийн илтгэл дэх эрүү шүүлтийн нөхцөл байдал, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрх, сэжигтэн яллагдагчийн эрхийн асуудлууд сэдвүүдийг жил бүрийн илтгэлд тусгай бүлэг болгон болгон судалгаа хяналт шалгалтын үндсэн дээр бичсэн/</p> <p>22. “Жендэр ба хүний эрх” сургалтын гарын авлага -2016 он</p> <p>23. “Хүний эрхэд суурилсан хандлага” сургалтын гарын авлага-2016 он</p> <p>24. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрхийн асуудлууд гарын авлага-2016 он</p> <p>25. Монгол Улс дахь хорих ангийн хөдөлмөр ба ялтны хөдөлмөр эрхлэлтийн байдал: Эмпирик судалгаа-2016 он</p> <p>26. Хууль сахиулагч ба Хүний эрх сургалтын гарын авлага-3-2017 он</p> <p>27. Хорих байгууллага ба хүний эрх сургалтын гарын авлага-4-2017 он</p> <p>28. Зэвсэгт хүчин ба хүний эрх гарын авлага-2018 он</p> <p>29. Ажлын байр- бэлгийн дарамтгүй орчин гарын авлага-2018 он</p> <p>30. Жендэр ба хүний эрх гарын авлага-2018 он</p> <p>31. Үндэстний цөөнхийн эрхийн гарын авлага-2018 он</p> <p>32. "Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх нь: Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа" Онол практикийн бага хурлын эмхэтгэл-2018 он</p> <p>33. Хүний эрх онол, арга зүйн сэтгүүл</p> <p><i>Дөрөв. Хэвлэлд нийтлүүлсэн өгүүлэл, нийтлэлийн мэдээлэл</i></p> <p>1. “Сэжигтэн, яллагдагчийн эрхийг баталгаатай хангах зарим асуудал”., “Хүний эрх” сэтгүүл, 2005 он, №1</p> <p>2. “Хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, шийтгэгдсэн хохирогчийн эрхийн асуудал”., “Хүний эрх” сэтгүүл, 2005 он, №2</p> <p>3. “Цагдан хорих ажиллагаа ба хүний эрх”., “Хүний эрх” сэтгүүл, 2005 он №4</p> <p>4. “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг хангахад анхаарах зарим асуудал”., “Хүний эрх” сэтгүүл, 2006 он, №1</p> <p>5. “Хүний эрх ба хүнийг хил дамнуулан худалдаалах гэмт хэргийн тухай”., “Хүний эрх” сэтгүүл, 2006 он, №2</p> <p>6. “Авилгалын эсрэг конвенц болон хүний эрхийн зарим асуудал”, “Монголын төр эрх</p>
--	--	--

		<p>зүй”, Улсын дээд шүүхийн сэтгүүл., 2006 он, №4</p> <ol style="list-style-type: none"> 7. Олон улсын гэрээ, хэлэлцээрийг шүүх, хуулийн практикт хэрэглэх нь”, “Хүний эрх” сэтгүүл, 2007 он, №1 8. “Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдүүдийн талаарх баримт, өнөөгийн нөхцөл байдал (шүүх, өмгөөлөх)”, “Монголын төр эрх зүй”, Улсын дээд шүүхийн сэтгүүл., 2007 он, №3 9. “Эрүү шүүлтийн хохирлыг нөхөн төлүүлэх олон улсын механизмыг Монголд хэрэглэх асуудалд”, “Эрх зүй”, МУИС-ийн Хууль зүйн сургууль, 2008 он, №3 10. “Эрүү шүүлтэд өртсөн хохирогчийг тодорхойлох болон хохирлыг арилгах арга хэмжээ”, “Монголын төр эрх зүй”, Улсын дээд шүүхийн сэтгүүл., 2008 он №3 11. “Цаазаар авах ял ба хүний эрх”, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2009 он, №3 12. “Монгол улс дахь 1921-1940 оны үеийн хэлмэгдүүлэлтийн үеийн эрүү шүүлт”, “Монголын төр эрх зүй”, Улсын дээд шүүхийн сэтгүүл., 2009 он, №3 13. “Эрүү шүүлтээс ангид байх эрх”, “Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл”, 2009 он, №3 14. Эрүү шүүлт цаазаар авах ялд илрэх нөхцөл байдал “Хүний эрх сэтгүүл”, 2011 он №1 15. Хүний эрхийг хангах, хамгаалах орчиг үеийн үзэл баримтлал, Хүний эрх сэтгүүл, 2011 он, №2 16. Олон улсын гэрээ конвенцийг шүүх хуулийн практикт хэрэглэх нь Хүний эрх сэтгүүл, 2012 он, №1 17. Хүний эрхийн Үндэсний байгууллагаас шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй өнөөгийн нөхцөл болон гарч буй хүндрэлүүд, Хүний эрх сэтгүүл, 2012 он, №2 18. Хүний эрхийн Үндэсний байгууллага нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм болох нь, Хүний эрх сэтгүүл, 2013 он, №1 19. “Дэлхийн улс орнуудын эрүүгийн процессын хуулиуд дахь хүний эрхийн хамгаалалт”, “Хүний эрх” сэтгүүл, 2017 он №1, 20. “Хүний эрхийн үндэсний байгууллагуудын гол үйл ажиллагаа” “Хүний эрх” сэтгүүл, 2017 он №2 21. “Эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүний эрхийн талаарх зохицуулалт: олон улсын гэрээ, хууль, практик” “Хүний эрх” сэтгүүл, 2018 он №1 22. “Төрийн байгууллага, албан тушаалтны буруутай ажиллагааны улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлж буй байдал” Хүний эрх” сэтгүүл, 2018 он №2 23. “Өмчлөх эрхийн олон улсын болон дотоодын эрх зүйн зохицуулалт” Хүний эрх” сэтгүүл, 2019 он №2 <p>Тав. Хурал, холбогдох арга хэмжээнүүдэд тавьсан зарим илтгэлүүдээс дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хотод 2019.06.27-2019.06.28-нд зохион байгуулагдсан Олон Улсын
--	--	---

		<p>Нотариатын Холбооны Азийн хэрэг эрхлэх Комиссын 9 дүгээр хуралд илтгэгчээр оролцож, “Өмчлөх эрхийн олон улсын болон дотоодын эрх зүйн зохицуулалт” сэдвээр илтгэл, Монголын Нотариатчдын Танхим, Олон Улсын Нотариатын Холбооны Азийн хэрэг эрхлэх Комиссын 9 дүгээр хурлын илтгэл, хэлэлцүүлгийн эмхэтгэл, 76-85 тал, 2019 он.</p> <ul style="list-style-type: none"> - Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос ний өдрүүдэд Хууль сахиулахын их сургууль дээр зохион байгуулсан хуралд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүний эрхийн талаарх зохицуулалт: олон улсын гэрээ, хууль, практик” сэдвээр илтгэл, 2018.03.03-04. - “Хүний эрхийн үндэсний байгууллагын гол үйл ажиллагаа” сэдвээр илтгэл, Төрийн ордон, 2017.11.28. - Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Нээлттэй нийгэм форумас Их тэнгэр цогцолборт зохион байгуулсан “Нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах нь” Олон улсын бага хуралд “Хүний эрхийн үндэсний байгууллагаас шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа өнөөгийн нөхцөл байдал болон гарч буй хүндрэлүүд” сэдвээр илтгэл, 2012.04.27, https://zindaa.mn/l4u - Гадаад харилцааны яам, Тагнуулын дээд сургууль хамтран Хууль зүйн хүрээлэнд зохион байгуулсан хуралд “Дэлхийн улс орнуудын эрүүгийн процессын хуулиуд дахь хүний эрхийн хамгаалалт” сэдвээр илтгэл, 2017 он. <p>Зургаа. Олон улсын арга хэмжээнүүдийн хүрээнд тавьсан илтгэлийн жагсаалт /2015-2020/</p> <ol style="list-style-type: none"> 1. “<i>Overview of barriers to the active and meaningful participation of women in armed forces, and other forms of sexual discrimination, harassment and abuse</i>” presentation at International workshop on “Preventing and Responding to Gender-Related Complaints in Armed Forces”, from 28-30 April 2015, Geneva, Switzerland. 2. “<i>Role of armed forces in a democracy</i>” and “<i>Protection of whistleblowers and best practices of NHRC of Mongolia</i>” presentations at 7th International Conference of Ombudsmen Institutions for the <i>Armed Forces</i>, from 25-27 October, 2015, Prague, Czech. 3. “<i>Mandate of National Human Rights Commission of Mongolia to deal with human rights violations caused by business activities</i>” presentation at Workshop Guaranteeing access to remedies for business-related Human Rights abuses: The role of NHRIs, from 2-3 March 2016, Rabat, Morocco. 4. “<i>Competence and role of the National Human Rights Commission of Mongolia in providing access to non-judicial remedy</i>” and “<i>Human rights implications in new and major business</i>”
--	--	--

		<p><i>sectors in Mongolia</i>” presentations at 2016 Asia Regional Forum on Business and Human Rights, from 19-20 April, 2016, Doha, Qatar.</p> <ol style="list-style-type: none"> 5. Asia Pacific Torture Prevention Ambassadors Project presentation as <i>Torture Prevention Ambassador</i>, 20-22 June 2016, Geneva, Switzerland. 6. “<i>Role of the NHRIs in ensuring the implementation of the sustainable development goals: Example of advocacy actions the National Human Rights Commission of Mongolia conducted in mining sector</i>” presentation at Human Rights and Sustainable Development Goals conference, from 26-27 November 2016, Kabul, Afghanistan. 7. “<i>National Inquiry on Torture in Mongolia</i>” presentation at National Human Rights Institutions (NHRIs) Foundation Training Workshop, from 19-20 April 2017, Astana, Kazakhstan. 8. “<i>Tackling the issue of impunity in Mongolia</i>” presentation at international conference “Identifying Challenges, Assessing Progress, Moving Forward: Addressing Impunity and Realizing Human Rights in South Asia”, from 9-11 April 2018, Kathmandu, Nepal. 9. <i>The NHRC’s role in promoting human rights education in Mongolia</i>” presented at Democracy Education in Asia Panel of Busan Democracy Forum 2019, from 14-16 October 2019, Busan, Korea. <p>Долоо. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд өгсөн ярилцлага, нэвтрүүлгүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Онцлох зочин, МҮОНТВ, 2019.11-р сар https://www.youtube.com/watch?v=VBNXH_hDghE 2. Орхон аймагт хөдөлмөрлөх эрхтэй холбоотой зөрчил их байна, ярилцлага, 2019.05-р сар, https://etzone.mn/2019/05/14713 3. Аливаа бодлого, шийдвэрийн хүрээнд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж болохгүй, ярилцлага, ETV, 2019.03.09 https://www.etv.mn/?p=2297 4. 12 жилийн тэвчээр, няцашгүй тэмцлийн дүнд шүүх хурал болж байна, ярилцлага, Зууны мэдээ сонин, 2019.01-р сар http://gogo.mn/r/9xlye 5. De Facto-ярилцлагын зочин, 2019.01 http://jargaldefacto.com/article/purewiin-oyuunchimeg-oyunchimeg-purev 6. Хүн бүр хүний эрхийн хамгаалагч байх боломжтой, ярилцлага, Өдрийн сонин, 2018.12.09 7. Сургагч багш нар цагдаа нартаа хичээл заах нь чухал, ярилцлага, Цагдаа сэтгүүл, 2018.11.27, https://police.gov.mn/a/4123 8. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох талаар санал хүргүүллээ, МҮОНТВ, 2018 он https://www.youtube.com/watch?v=peRG4cG9D7I&t=3s 9. Хил дээр хөдөлмөрлөх эрхийн зөрчил маш их байна, ярилцлага, 2018.03.06 http://www.control.mn/i/14803#.XrEW56gzblU 10. Хүүхдийн эрхийг ноцтойгоор зөрчиж, хүчирхийлсэн гэдгийг хэний ч нүднээс нууж
--	--	---

		<p>чадахгүй баримт нь өсвөр насны хүүхдийн жирэмслэлт, ярилцлага, өдрийн сонин, 2017 он. 12-р сар 1613 охидыг насанд хүрээгүй байхад нь ээж болгосон этгээдүүд ял завшиж байна, 2017.11.02, http://time.mn/IJJ.html</p> <p>11. Зочны цаг, ярилцлага, МҮОНТВ, ММ агентлаг https://www.youtube.com/watch?v=SXZCGUAaq4Q</p> <p>12. “Бэлгийн дарамт үйлдсэнийг нь нотлохоор өөр байгууллагын даргаар томилчихдог”, ярилцлага, “Зууны мэдээ” сонин, 2017.11.07 https://ikon.mn/n/1pv3</p> <p>13. Илэн далангүй ярилцъя, Го.Бадарч, ярилцлага 2017 он https://www.youtube.com/watch?v=E5Wl9mF-fr4</p> <p>14. Зочны цаг, ярилцлага, С1, 2015 он https://www.youtube.com/watch?v=jchGcJLTcx4</p> <p>15. "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрх" олон нийтийн лекц, 2015 он https://www.youtube.com/watch?v=qKj3iO5XjEo</p> <p>16. Эрүү шүүлтийн эсрэг элчин сайд, ХЭҮК-ын гишүүн П.Оюунчимэг, 2015 он, https://www.youtube.com/watch?v=4TCKmZTg9QM</p> <p>17. Ярилцах танхим, ТМ телевиз, 2015 он https://www.youtube.com/watch?v=7IMWABP_2-w</p> <p>18. Хүний амьд явах эрхийг зөрчигч хамгийн том субъект нь төр, ярилцлага, Өнөөдөр сонин, 2014 он</p> <p>19. ШШГЕГ-т хүний эрх зөрчигддөг нь үнэн, ярилцлага, 2014 он, https://och.mn/4162</p> <p>20. Яах аргагүй хүний эрх зөрчигдсэн, ярилцлага, 2014 он https://mass.mn/n/4248</p> <p>21. Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны талаар, ярилцлага, МҮОНТВ, ММ агентлаг, 2014 он, 02-р сар, https://www.youtube.com/watch?v=f2h5ZJ0pt48</p> <p>22. Хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаална, МҮОНТВ, 2014 https://www.youtube.com/watch?v=VaK_NodM-jE</p> <p>23. Хүний эрхийн асуудал Монголд, ярилцлага, ETV, "Тод зочин" нэвтрүүлэгт, 2014.02.20, https://www.youtube.com/watch?v=-QpiljFyRp8</p> <p>24. “Өнөөдөр Цээл сумыг, маргааш бүхэл бүтэн аймгийг нүүлгэх тухай асуудал сөхөгдөж мэднэ”, ярилцлага, https://www.biznetwork.mn/content/8963</p> <p>25. Шарил задланд орчихсон юм байна, ярилцлага, Өглөөний сонин, 2013 оны 12 сар 13, https://www.ugluu.mn/52001.html</p> <p>26. Гэмт хэргийн тухай хуулийн хэлэлцүүлэг, ETV, 2013 https://www.youtube.com/watch?v=pYYw9eb5VpA</p> <p>27. Эрүүдэн шүүлтийг таслан зогсоох асуудлаар, ярилцлага, ТВ5, 2013 он, https://www.youtube.com/watch?v=97zjxZU0Ox</p> <p>28. Хүний эрхийн олон улсын өдрийг тэмдэглэж байна, тодруулга, ТВ5, 2013 он https://www.youtube.com/watch?v=2vzbSfHMIJ4</p> <p>29. Өдрийн зочин, ярилцлага ETV, 2013 он, https://www.youtube.com/watch?v=0z0MwekDoPM</p>
--	--	---